



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 23 өдөр

Дугаар А/544

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4.а Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын үр өгөөжийг сайжруулах зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Бадамлах дөл" ХХК, Ховд дулааны станц" ТӨХК, Шим-Ус орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, Ховд Цахилгаан түгээх Сүлжээ ХХК-ний өвөлжилтийн бэлтгэл ажил дулааны улирал эхлэхтэй холбоотой бэлэн байдал, хийгдсэн засвар үйлчилгээний ажлыг шалгах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- | | | |
|-----------------------|-----------------|---|
| Ажлын хэсгийн ахлагч | Б.Баярсүх | -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга |
| Гишүүд | Р. Янжмаа | - Аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн |
| | Ц.Цогтбаяр | -Жаргалант сумын Засаг даргын орлогч |
| | Б.Түмэндэмбэрэл | - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн |
| Нарийн бичгийн дарга: | Д.Эрдэнэбат | -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн гэрээт ажилтан |

2. Өвөлжилтийн бэлтгэл ажил дулааны улирал эхлэхтэй холбоотой бэлэн байдал, хийгдсэн засвар үйлчилгээний талаар ажлыг шалгасан тайланг танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч / Б.Баярсүх /-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



T. Jargalsaihan

Т.ЖАРГАЛСАЙХАН